

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ

Т.ЖАМБААЖАМЦ
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ
ХОРООНЫ АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

НИЙЛҮҮЛЭГЧ

Т.ЭНХБАГАНА
“БИД ТЕХНОЛОГИ” ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

ЗӨВШӨӨРЛИЙН ЦАХИМ СИСТЕМ, ТАЙЛАН МЭДЭЭНИЙ СИСТЕМ, ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ СИСТЕМ БАЙРШИЖ БУЙ СЕРВЕР, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН АВТОМАТ ТОХИРГООНЫ СИСТЕМИЙН ЛИЦЕНЗ ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

Дугаар №

2024 оны 3 дугаар сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

Нэг талаас Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “захиалагч” гэх)-г төлөөлж Мэдээллийн технологийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Оюунчимэг, нөгөө талаас “Бид технологи” ХХК (цаашид “нийлүүлэгч” гэх)-г төлөөлж Гүйцэтгэх захирал Т.Энхбагана нар дараах зүйлийг харилцан тохиролцож энэхүү Зөвшөөрлийн цахим систем, тайлан мэдээний систем, эрсдэлийн үнэлгээний систем байршиж буй сервер, тоног төхөөрөмжийн автомат тохиргооны системийн лиценз худалдах, худалдан авах гэрээ цаашид “гэрээ” гэх)-г байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь “Зөвшөөрлийн цахим систем, тайлан мэдээний систем, эрсдэлийн үнэлгээний систем байршиж буй сервер, тоног төхөөрөмжийн автомат тохиргооны системийн лиценз” худалдан авах тендерийн баримт бичигт заасан бараа (цаашид “бараа” гэх)-г 45,650,000 /дөчин таван сая зургаан зуун тавин мянга/ төгрөгөөр (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв.
3. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
4. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
5. Нийлүүлэгч нь 1 нэр төрлийн 2 ширхэг системийн лиценз /бараа/-г нийлүүлэлтийн хуваарьт заасны дагуу нийлүүлж, гэрээ дүгнэсэн актаар хүлээлгэж өгнө.
6. Захиалагч нь гэрээний үнийг гэрээний тусгай нөхцөлд зааснаар 2 үе шаттайгаар буюу гэрээний нийт үнийн дүнг 80%, 20%-иар хувааж гүйцэтгэгчид төлнө.
7. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:
Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг¹;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;

¹ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ дүгнэсэн акт, нэхэмжлэх

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

8. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл, алдаа, зөрчлийг арилгах үүрэг хүлээнэ.
9. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл, алдаа, зөрчлийг арилгах, үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
10. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичиг, цахим шуудан, утас болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Мэдээллийн технологийн хэлтсийн
даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

_____ Н.Оюунчимэг

Мэдээллийн технологийн хэлтсийн референт

_____ Б.Лхагвасүрэн

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

“Бид технологи” ХХК-ийн
гүйцэтгэх захирал

_____ Т.Энхбагана

ТАМГА

Захиалагчийн хаяг
УБ хот, ЧД. Бага тойруу-3,
Засгийн газрын IV байр
Утас: 51-264444
И-мэйл: info@frc.mn

ТАМГА

Нийлүүлэгчийн хаяг:
УБ хот, Баянзүрх дүүрэг, 14-р хороо,
14-р хороолол, 866-65 тоот
Утас: (976)-88009951, 88113356
Харилцагч банкны нэр: Хаан банк
Дансны дугаар: 5629064782

ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|--|---|
| 1. Шалгах
2. болон
турших | 2.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 3. Барааны
нийлүүлэлт
ба баримт
бичгийн
бүрдүүлэлт | 3.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 4. Оюуны
өмчийн эрх | 4.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 5. Бараа хүргэх,
тээврийн
баримт бичиг
ирүүлэх | 5.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 6. Баталгаат
засварын
хугацаа | 6.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа 1/нэг/ жил байна. |
| 7. Гэрээнд
өөрчлөлт
оруулах | 7.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 8. Төлбөр | 8.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [ажлын 14 хоногийн дотор] хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 9. Бараа
нийлүүлэх
хуваарь | 9.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 10. Алданги
оногдуулах | 10.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 11. Үүргээ
биелүүлээгүй
-гээс гэрээг
цуцлах | 11.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |

- 12. Маргааныг шийдвэрлэх** 12.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- 1. Шалгах болон турших (ГЕН – 1)** 1.1. [Албан бичгийн системийн эрхийн хувьд СЗХ-ны дотоод албан бичиг, хэргийн дүрэм, журамд заасны дагуу тохируулга хийж туршиж хүлээлгэн өгөх]
- 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН 2)** 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) Нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
 - 2) Барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
 - 3) Үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн засварын баталгаа.
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
- 3. Баталгаат засвар (ГЕН-5)** 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага. Бараа нийлүүлснээс хойш 1 жил байна.
- 4. Төлбөр (ГЕН – 7)** 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
- Гэрээний үнийн дүнгийн 80% болох 36,520,000 /гучин зургаан сая таван зуун хорин мянга/ төгрөгийг гэрээ байгуулж, нийлүүлэгчээс төлбөрийн нэхэмжлэх ирүүлснээс хойш ажлын 14 хоногийн дотор шилжүүлнэ. Гэрээний үлдэгдэл төлбөр 20% буюу 9,130,000 /есөн сая нэг зуун гучин мянган/ төгрөгийг лицензийг бүрэн хүлээн авсан акт, нийлүүлэгчийн төлбөрийн нэхэмжлэхийг хүлээн авсанаас хойш ажлын 14 хоногийн дотор төлнө.
- 5. Алданги оногдуулах (ГЕН - 9)²** 9.1. Алданги оногдуулах хувь: Хугацаа хэтэрсэн хоног тутам гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.1% байна.
- Алдангийн нийт дүн: Алданги ногдуулах нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10% байна.
-

НИЙЛҮҮЛЭХ БАРААНЫ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. Лиценз

Д/д	Барааны нэр, төрөл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
1	VMware vSphere 7 Essentials Plus Kit лиценз	Ш	1
2	VMware vCenter Server Standard for vSphere 7 лиценз	Ш	1

2. Бараа хүргэх газар: *Чингэлтэй дүүрэг, Бага тойруу 3, Засгийн газрын IV-р байр, Санхүүгийн зохицуулах хороо*

3. Бараа нийлүүлэлтийн хуваарь:

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа	
				Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа
1	3	4	5	6	7
VMware vSphere 7 Essentials Plus Kit лиценз	1	ш	Санхүүгийн зохицуулах хороо	Гэрээ байгуулагдсан өдрөөс эхлэнэ	2024.4.1
VMware vCenter Server Standard for vSphere 7 лиценз	1	ш	Санхүүгийн зохицуулах хороо	Гэрээ байгуулагдсан өдрөөс эхлэнэ	2024.4.1